



MONGOLSKÁ
POHÁDKA





Bílá Kobyla
a její hříbě



Цуутын
цагаагч гуу





Byla jednou jedna krásná bílá klisna a ta měla bílé hříbě. Žila ve stádu společně s ostatními koblami a plavým hřebcem. Jednoho léta uhodila sucha a na rozlehlých pláních nebyla žádná pastva.

„Musíme odtud odejít,“ řekla bílá kobyla plavému hřebci a stádo opustilo rodné pastviny.

Tři léta koně chodili a marně hledali zelenou travu, až konečně přišli na pastvinu se šťavnatou travičkou, čistou vodou a bystře tekoucí řekou. Usadili se tu.

Jednou dováděli na břehu řeky a rozdupali sedm husích vajec. „Běda,“ zaúpěla bílá kobyla. „Musíme honem odtud. Přišli jsme na cizí pastviště a rozšlapali vejce. Husy se nám teď pomstí. Na úsvitu sem přiletí jejich vojsko a zničí nás. Pojdme se vrátit.“ Koně však neposlechli a zůstali.

Nazítří ráno přiletělo husí vojsko a uklovalo všechny koně. Zachránila se pouze bílá kobyla se svým hříbětem. Když husy útočily, snažila se ochránit hříbě svým tělem a utíkala s ním do stepi. Ale rozzlobené husí vojsko je pronásledovalo. Když husy klovaly z pravé strany, kobyla ukřývala hříbě pod levým bokem, když je napadaly zleva, ukřývala kobyla své hříbě pod pravým bokem. Husy přepadaly zepředu, kobyla schovala





hříbě za sebou, a když přepadaly zezadu, ukřývala kobyla své hříbě před sebou. Husí vojsko se nakonec unavilo a odletělo.

„A teď půjdeme na rodné pastviny, synku,“ řekla hříběti. Za měsíc ušli cestu, která obvykle trvá rok, a za den cestu, která obvykle trvá měsíc.

„Mámo, slyšíš, mámo!“ Proč máš tak drsnou kůži?“ zeptalo se jí jednou hříbě. „To asi jak se mi na ni nalepilo bodláčí, synku.“ „Mámo, slyšíš, mámo! A proč máš tak červenou kůži?“ zeptalo se opět hříbě. „To se na mne nalepila červená hlína, synku, jak jsme procházeli průsmykem.“ „Mámo, mámo! A proč se ti třesou nohy?“ „Únavou. Mnoho cest jsem prošla a mnoho řek přeplavala.“ Konečně matka dovedla syna až na rodné pastviště a brzy nato umřela.

Před smrtí nakázala hříběti: „Synku, neuléhej ke spánku na severní straně. Fičí tam vánice a přicházejí odtud vlci. Uléhej na jižní straně, kde je klid. Jurtám se zdaleka vyhýbej, sic se na tebe vrhnou děti a psi, dříve než se naděješ! Neuléhej na místě, kde předtím stávala jurta, mohl by ses píchnout jehlou. Ve stádu chodívej vždy po kraji, ale k napajedlu běhej první. Nemotej se vzadu za stádem, sic tě hospodář zbijí.“





Nechodívej uprostřed stáda, nebo tě ostatní koně ušlapou k smrti. A za tři roky se přijď poklonit mému prachu, synku!”

Hříbě však nedbalo matčiných rad. Uléhalo na severní straně a div nezmrzlo ve vichřici, jindy ho zas div nezadávali vlci. Hříbě si poplakalo a běželo dál a najednou si vzpomnělo na matku. Jak dobře mi matka radila, řeklo si a začalo uléhat na jižní straně, kde byl klid.

Zapomnělo však na jinou matčinu radu a mnohokrát šlo těsně kolem jurty. Sběhli se na něho psi a děti ho bily klacky. Hříbě trpce naříkalo a myslelo si: „Jak dobře mi matka radila!” A začalo se jurtám zdaleka vyhýbat.

Matka mu radila, aby běhalo k napajedlu před stádem, že bude pít čistou vodu, ale hříbě běhalo uprostřed stáda, koně jej však div neušlapali. Teprve pak chodilo po kraji a poháněč je nebil, koně nekopali, trávu mělo čerstvou – a hned mu bylo veseleji na světě.

Jak moudře mi matka radila, říkalo si opět v duchu.

Zastesklo se mu po ní a ještě než uplynula stanovená lhůta, rozběhlo se k místu, kde umřela.

Nalezlo tu její pozůstatky. Odešlo a přesně za tři roky přišlo opět. Teď už tu rostla hustá šřavnatá





tráva. Hříbě ji spáslo, pokývalo hlavou a šlo dál. Cestou potkalo mládence Erchije Mergenču. „Chceš být mým koněm?“ zeptal se ho mládenec. „Chci,“ pravilo hříbě, „ale musíš si mě chytit.“ Mládenec hříbě chytil, nasadil mu stříbrnou uzdu a osedlal jej stříbrným sedlem. „Tak,“ prohlásil kůň, „teď srovnám svými kopyty horu a hlínu rozmetám po stepi. Jestli se na mně udržíš, jsi opravdový muž. Jestli ne, pak nejsi můj pán.“

Kůň srovnal horu se zemí, hlínu rozmetal po stepi – ale Erchij Mergenču se přesto udržel v sedle. Tak našel pán svého koně a kůň svého pána.





Цуутын цагаагч гүү цолмон цоохор унага, далан хоёр ижил сүрэг, дархан хул азаргатайгаа үзэсгэлэнт ногоон хөндийдөө идээшлэн бэлчдэг байжээ. Гэтэл нэгэн зун үзэсгэлэнт ногоон хөндий, өргөн тал нутагт нь ган гачиг болж өвс ногоо ургасангүй.

Тэгэхээр нь цуутын цагаагч гүү далан хоёр ижил сүрэг, дархан хул азрагатайгаа хамт нутгаасаа гарч гурван жилийн газар өвсний шимийг хөөн алсын аянд гарчээ. Тэгж явсаар тэд өвс ногоо тэгширсэн үзэсгэлэнт нутагт ирцгээв. Тэд тэнд нутаглаж усны сайнаар умдаалж, өвсний сайныг идэж, хужрын сайныг долоон хөөцөлдөн тоглодог байлаа.

Гэтэл тэрхүү голын хөвөөн дээр галууны долоон өндөг байсныг сүргийхэн мэдэлгүй хага гишгэж орхижээ. Тэр даруй цуутын цагаагч гүү далан хоёр ижил сүрэг, дархан хул азаргандаа ийм нэгэн сануулга өгчээ. “Одоохон эндээс явцгаая. Бид хүний нутагт дураараа ирж долоон цагаан өндгийг нь гишиглэн хөнөөлөө. Тиймээс энэ нутгийхан биднийг одоо дайснаа гэж үзэх болно. Тун удахгүй өглөөний мандах нарнаар шувуун сүрэг ирээд биднийг довтлон





хөнөөх болно” гэв. Гэвч ижил сүрэг нь цуутын цагаагч гүүний үгэнд оролгүй бяцхан шувуудыг басамжлан дооглосоор зугаа цэнгэлээ үргэлжлүүлжээ.

Гэтэл маргааш өглөөний ургахын улаан нарнаар үнэхээр шувуун сүрэг ирж цуутын цагаагч гүүний далан хоёр ижил, дархан хул азаргыг нь тоншиж алаад дуусгажээ. Ганц цуутын цагаагч гүү л цолмон цоохор унагатайгаа амь гаран зугтжээ. Гэвч хорсож бухимдсан шувуун сүрэг эх хүү хоёрыг хөнөөх гээд бүслэн довтолохоо зогссонгүй. Ингэсээр тэдний байлдах сум нь цөөрч зөвхөн нэг талаас нь харван довтолох болов. Хойд талаас нь довтолоход цуутын цагаагч гүү унагаа урд талдаа авч хамгаалав. Өмнө талаас нь довтолоход унагаа хойд талдаа авч хамгаалжээ. Бухимдаж уурласан шувуун оруулан хамгаалжээ. Ингэсээр шувуун сүрэг ч залхаж ядраад, сум зэвсэг нь ч элэгдэж дуусаад, цуутын цагаагч гүүг унагатай нь хамт орхиод буцжээ.сүрэг дахин газрын газрын доод талаар довтолон харвахад гүү унагаа газрын дээд талд гарган хамгаалав. Чанх дээрээс нь дайран довтолоход унагаа доороо оруулан





хамгаалжээ. Ингэсээр шувуун сүрэг ч залхаж ядраад, сум зэвсэг нь ч элэгдэж дуусаад, цуутын цагаагч гүүг унагатай нь хамт орхиод буцжээ.

Цолмон цооохор унагаа эсэн мэнд авч үлдсэн цуутын цагаагч гүү гурван жилийн цаана байгаа нутгийн зүг буцахаар сарын газрыг өдрөөр өдрийн газрыг сараар товчлон явав. Гэтэл нэгэн өдөр цолмон цооохор унага ээжээсээ:

– Ээжээ, ээжээ таны биеэр нэг сарайж сэрийсэн энэ их зүйл чинь юу вэ? гэж асууж гэнэ.

Цуутын цагаагч гүү хариуд нь:

– Харгана буттай давааг давахад шивээ үзүүртэй өвс л наалдаа биз дээ гэв. Гэтэл унага дахиад л:

– Ээжээ, ээжээ. Таны биеэс оргилж урсаад байгаа улаан улаан юм юу вэ? гэж асуув. Хариуд нь цуутын цагаагч гүү:

– Зостын улаан даваагаар давахад зосонд будагдсан улаан шавар наалдаа биз ээ гэжээ.

Хэсэг явж байгаа унага дахиад л:

– Ээжээ, ээжээ товор товор явдалтай тэгшхэн цагаан хөл чинь юунд солбиж гуйваад байгаа юм бэ гэв.





– Хүү минь, газрын хол усны уртад ядраад тэр биз дээ гэв. Ийнхүү явсаар тэд нутгийн захад иржээ. Энэ үеэр цуутын цагаагч гүү шувуун сүргийн довтолгооноос олсон шархаа даахгүй удалгүй нас нөгчих нь гэдгээ ойлгоод сүүлчийн удаа унагандаа захиас үгээ хэлжээ:

– За хүү минь. Ар газраар битгий яваарай шуурга ихтэй учраас чоно эргээд байдаг юм шүү. Өвөр газар унтаж яваарай. Нөмөртэй дулаахан байдаг юм. Айлын үүдээр битгий гараарай. Хүүхэд нохой ээрээд явуулдаггүй юм. Тиймээс араар нь тойрч гараарай. Нүүсэн айлын буурин дээр битгий хоноглоорой, зүү тэвнэ шорлоод цоо хатгачиж мэднэ. Ижил сүрэгтэйгээ явахдаа заавал захад нь идээшилж байгаарай. Харин ус ууж цангаага тайлах бол хамгийн түрүүнд орж байгаарай. Адууны сүүлд орвол эзэн нь зодож цохиод хэцүү байдаг юм. Харин дунд орвол дайрч өшиглөж алчих гээд амаргүй. Хүү минь ээжийнхээ булшин дээр гурван жил болоод ирээрэй. Ингэж захиад цуутын цагаагч гүү нас нөгцөжээ.

Цолмон цоохор унага ганцаар үлдээд ээ-





жийнхээ захисныг мартчижээ. Ар газар унтахад нь салхи шуурга дааруулж чоно барьж идчих гээд амаргүй байлаа. Цолмон цоохор унага “Ээжийн минь захисан үг юутай үнэн билээ” хэмээн байн байн уйлсаар өвөр газар амгалан тайван унтаж амардаг болов.

Дараа нь Цолмон цоохор унага айлын үүдээр гарч яваад хүүхдэд ноолуулж, нохойд хөөгдөн зүдэрчээ. Үүнээс хойш тэр айлын ар талаар сэмхэн тойрч гардаг болов.

Ижил сүргийнхээ өмнө гараад ус уувал хамгийн тунгалаг сэрүүн усыг уух ажээ. Олон адууны сүүлд орж яваад нэг удаа эзэнд нь зодуулж нүдүүлэн золтой л бэртэж гэмтсэнгүй. Тэгэхээр нь унага нуун нуун уйлсаар сүргийн голд ороод явтал тал талаас нь өшиглөж тийрч алчих гээд амар заяа үзүүлсэнгүй гэнэ. Ингээд унага ээжийнхээ үгийг эргэж нэг санаад ижил сүргийнхээ захад нь гарч үзвэл эзэн хүнд нь зодуулалгүй ижил сүрэгтээ өшиглүүлэлгүй өвсний шинийг идэж ая тааваараа явах болжээ. Ээжийн минь хэлсэн үг юутай үнэн байж вэ гэж бодсоор унага толгойгоороо тоглож тоосноосоо бусагасаар гурван жилийн нүүр үзэв.





Цолмон цоохор унага ачит эхийнхээ булшин дээр очих цаг болсныг мэдээд газрын холыг тэмцэн зүтгэсээр зорин иржээ.

Гэтэл унасан газар нь бал бурам ургасан байлаа. Түүнийг нь идээд нарлан тонгочиж байтал нэгэн мэргэн хөвгүүн тааралджээ.

Тэр хүү унаганаас:

– Чи миний хүлэг мөн үү?” хэмээн асуув.

Хариуд нь унага:

– Чи миний эзэн мөн үү? хэмээн асуужээ.

Хүү:

– Би чиний эзэн мөн билээ гэхэд унага:

– Тэгвэл чи намайг барьж ав. Тэгээд би уулыг тал болтол, талыг там болтол бусгая гэв.

Эрэмгий мэргэн хүү хээрийн салхинаас өөр зүйл нуруун дээрээ гаргаж үзээгүй Цолмон цоохор унагыг барьж аваад мөнгөн тоногоор чимэглэв. Тэгээд уулыг тал болтол талыг там болтол бусгасан унагыг номхотгож авав.

Ингэж эзэн нь морио таньж морь нь эзнээ таньснаар унага айх аюулгүй амар сайхан амьдрах болжээ.





Autoři projektu:
Petra Holubářová, Lucie Machová
Převyprávění pohádky:
Otgon-Erdene Erdenebat
Ilustrace a grafické zpracování:
Michaela Casková

InBáze, z.s.
2019



EVROPSKÁ UNIE
Evropské strukturální a investiční fondy
OP Praha – pól růstu ČR



 MĚSTSKÁ ČÁST PRAHA 2

 Městská knihovna v Praze


MINISTERSTVO ŠKOLSTVÍ
MLÁDEŽE A TĚLOVÝCHOVY

 INBÁZE





